

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

**ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ЭРХИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХИ СУДАЛГААНЫ  
УДИРДАМЖ ТАЙЛАН**

**2006 ОН**

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

## Хурдны морь унадаг хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах судалгааны ажлын тайлан

Хурдны морь унадаг хүүхдийн эрхийн байдлыг хянах судалгааг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “АЙПЕК” хөтөлбөрөөс санхүүжүүлж, Хүний Эрхийн Үндэсний Комисс гүйцэтгэгчээр ажиллаж, хөдөө орон нутаг дахь, тус Комиссын итгэмжлэгдсэн төлөөлөгчид, аймгийн хүүхдийн төлөө төвтэй хамтран хийж гүйцэтгэж, аймгаас ирүүлсэн судалгааны дүнг Комисс дээр нэгтгэж дүгнэлт хийсэн болно.

### 1. Судалгааны зорилго:

Монголчуудын эрт дээр үеэс уламжлан ирсэн баяр цэнгэл наадмын нэг төрөл болох хурдан морины уралдаан нь сүүлийн жилүүдэд ихээхэн өөрчлөгдөж, хурдан морины уралдаан өвөл зунгүй зохион байгуулагдаж, нэг уралдаанд уралдах морины тоо үлэмж өсөж, хурдан морины уралдааны явцад хүүхэд амь насаа алдах, бэртэж гэмтэх, хөлс урамшуулалгүй ажиллах зэргээр эрх нь зөрчигдөж байгаа талаар шүүмжлэгдэх болсон байна. Гэсэн хэдий ч энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийсэн, баримт цуглуулсан тохиолдол байхгүй байна.

Иймд морины уралдааны явцад унаачхүүхдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах, хүч хөдөлмөрийг үнэлэх асуудал ямар түвшинд байгаа, ямар зөрчил, эрсдэл гардаг талаар мэдээлэл цуглуулж дүгнэлт хийх нь судалгааны ажлын гол зорилт байсан болно.

### 2. Судалгааны хамрах хүрээ, хугацаа:

Судалгааг бүх аймаг, орон нутагт сүүлийн жилүүдэд зохион байгуулагдсан улсын баяр наадам, бусад ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан зохион байгуулагдаж байгаа бүх морин уралдааныг хамруулан мэдээлэл цуглуулах зорилт тавьсан болно. Судалгаа хийхэд

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

орон нутгийн төр захиргааны болон төрийн бус байгууллагад морин уралдаан зохион байгуулагдсан талаархи баримт бичгийг судлах зорилт тавьсан боловч ийм баримт бичиг маш ховор байгаа болох нь харагдаж байна. Ийм баримт байсан ч хэдэн морь уралдсан, хэний морь түрүүлсэн, хэний морь айрагдсан талаархи товч мэдээлэл байдаг байна. Харин морин уралдааны явцад ямар зөрчил гарсан, хэдэн хүүхэд мориноос унасан, ямар гэмтэл бэртэл авсан, хэд нь даатгалд хамрагдсан талаар тусгагддаггүй байна. Судалгааг Өвөрхангай, Дархан-Уул аймгаас бусад аймаг хамрагдаж судалгааны тайлангаа ирүүлсэн болно.

Судалгааг орон нутгийн засаг захиргааны байгууллага, тэдгээрийн хүүхдийн эрхийн асуудал хариуцсан ажилтан, аймаг, сумдын баяр наадмын болон аливаа уралдаан зохион байгуулсан байгууллага, иргэд, эмнэлгийн болон даатгалын байгууллага, уяачдын холбоодод байгаа баримт, мэдээлэлтэй танилцах, хурдан морины комиссын дарга, гишүүд, уяачид, иргэд, хурдан морь унаач хүүхдүүдтэй уулзаж ярилцах зэргээр мэдээлэл цуглуулж хийсэн болно.

Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийг судлах судалгааны удирдамжийг “АЙПЕК” хөтөлбөртэй зөвшилцөн болвсруулж, судалгаа явуулах удирдамж, хийх ажил, арга зүйн талаар ХЭҮК-ийн ажилтнуудыг цуглуулан, зөвлөлгөө өгч, хамтарсан судалгаа явуулах тухай ХЭҮК, ХТҮГ-ын даргын хамтарсан албан бичгийг бүх аймгийн Хүүхдийн төлөө төвүүдэд хүргүүлсэн.

### **3. Судалгааны үр дүнгийн талаар:**

Хурдан морины уралдааныг зохион байгуулах эрх зүйн зохицуулалтын талаар:

Монгол оронд уламжлалт морин уралдааныг улсын баяр наадам, аймаг, сумдын ойгоор ихэвчлэн зохион байгуулдаг байсан ба сүүлийн жилүүдэд морин уралдаан зохион байгуулах тохиолдлууд маш олон хэлбэртэй болсон байна. Үүнд:

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

- улсын баяр наадам
- улсын чанартай бүсчилсэн уралдаан /их хурд/
- аймаг, сумдын ой
- цагаан сар
- сонгуулийн сурталчилгаа
- албан байгууллага, албаны ой
- хувь хүний насны ой,
- зарим нэг уяачдын нэрэмжит уралдаан
- хувь хүний алдар цол хэргэм хүртсэнийг тэмдэглэх
- газар лус, овоо тахилга
- бооцоот уралдаан гэх мэт 10 гаруй төрлийн үйл явдлыг тохиолдуулан морин уралдаан зохион байгуулах болсон байна.

Монгол Улс 2003 оны 6-р сард Үндэсний их баяр наадмын тухай хуулийг батлан гаргаж, энэ хуулиараа үндэсний баяр наадмаар морин уралдаан зохион байгуулахад баримтлах зарим нэг зохицуулалтыг хийж өгсөн нь асуудлыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх эхний алхам болсон байна.

Энэ хуулиар хурдан морийг 7-гоос дээш насны хүүхэд унах ба тухайн хүүхэд ослын даатгалд даатгуулсан байна хэмээн заасан ба Засгийн газраас хурдан морины уралдааны дүрмийг батлахаар заасан.

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 6-р сарын 7-ний 119-р тогтоолоор хурдан морины уралдааны дүрмийг шинэчлэн баталсан байна. Дүрмэнд хүүхдийн хамгааллын шинжтэй дараах заалтууд тусгагдсан байна.

- хурдан морины хүүхрэд нь хамгаалалтын малгай, цээживч, өвдөг, тохойн хамгаалалт, хамгаалалт бүхий дөрөөтэй эмээлтэй байх,
- морийг 7-оос дээш настай, морь унаж давхиулж сурсан, эрүүл хүүхдээр унуулах,
- хүүхдийг морь унуулхаар албадахгүй байх,
- түрүүлсэн, айрагдсан моринд олгосон бай шагналын 20 хувийг унасан хүүхдэд олгох,

- хүүхдийг ослын даатгалд заавал даатгуулах,
- хамгаалах хэрэгслийг морь, хүүхдийн биед тохируулж, аюулгүй байдлыг хангасан байх,
- морийг бүртгэхдээ хүүхдийн төрсний гэрчилгээ, ослын даатгалын баталгаа, эцэг эхийн зөвшөөрлийг үзэж бүртгэх

гэх мэт заалтуудыг тусгаж өгсөн байна. Эдгээр заалтууд нь урьд өмнө огт зохицуулалтгүй, хурдан морь унаж болох насны доод хязгаар огт байхгүй байсан, даатгалын тухай яригддаггүй байсныг бодоход дэвшилттэй алхам болсон байна. Хурдан морины уралдааны тухай дүрмээр хуулиасаа илүү нарийн зохицуулалтыг хийсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр эрх зүйн баримт бичигт дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна

- Эдгээр баримт бичгүүд нь зөвхөн үндэсний их баяр наадам, Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдаж байгаа морин уралдаанд хамааралтай байгаа тул эдгээрээс бусад морин уралдааныг зохицуулах боломжгүй учир нийтлэг ач холбогдолтой биш байна.
- Хурдан морь унаж болох насны доод хязгаарыг 7 насаар тогтоосныг судлан үзэх шаардлагатай байна. Энэ нас бол хүүхдийн хувьд аливаа эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадвар бүрэн суугаагүй, оюун ухаан, бие бялдрын хувьд гүйцэт төлөвшөөгүй, бага нас гэж үзэх үндэстэй.

Дүрмээр морь унуулж давхиулж сурсан, эрүүл хүүхдээр морь унуулна гэсэн ч энэ шалгуурыг хянах зохицуулалтыг хийж өгөөгүй байна.

- Хамгаалалтын хувцастай байхаар тусгагдсан эдгээр хувцасны үзүүлэлт шаардлагууд тодорхой биш байна.
- Хурдан морины уралдааны явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд учирсан гэмтэл бэртэлийг нарийвчлан шалгаж шалтгаан нөхцлийг тогтоодог, мэдээлдэг зохицуулалт байхгүй байна.

### 3.1 Хүүхдийн амь нас эрсэдсэн талаар

Хурдан морины уралдааны явцад хүүхдийн амь нас эндэх явдал гардаг гэж ярьдаг боловч энэ тохиолдлыг судлан бүртгэсэн шалтгаан нөхцлийг судалсан тохиолдол байдаггүй. Судлаачид эдгээр тохиолдлыг эрэн сурвалжлах, иргэд, хурдан морь унаач хүүхдүүдээс асуух зэргээр тодруулж үзсэн байна. Судалгааны явцаас ажиглахад морин уралдааны явцад хүүхдийн амь нас эрсэдсэн тохиолдлыг захиргааны түвшинд бүртгэж судалсан, эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан тохиолдол байдаггүй байна


Хурдан морины уралдааны явц дахь хүүхдийн эрхийн судалгаагаар сүүлийн жилүүдэд 17 хүүхэд морин уралдааны явцад мориноосоо унаж нас барсан тухай мэдээлэл цуглуулсан байна. Эдгээр 17 тохиолдлын хоёроос бусад нь 2000 оноос хойш болсон морин уралдааны явцад гарсан байна.

Оноор нь авч үзвэл:

- 1996 онд 1
- 1998 онд 1
- 2001 онд 1
- 2003 онд 3
- 2004 онд 4
- 2005 онд 5
- 2006 онд 2

Дээр дурьдсан үзүүлэлтээс харахад 2003 оноос хойш гарсан тохиолдлууд илүү өндөр үзүүлэлттэй харагдаж байгаагаас үзвэл сүүлийн жилүүдэд мориноос унаж эндсэн хүүхдийн тоо сүүлийн 4 жил дараалан өсөх хандлагатай болсон гэж үзэж болохоор байна.

Морин уралдааны явцад хүүхэд эндсэн дээрхи тохиолдлууд 21 аймгийн 11 аймагт нь бүртгэгдсэн байна. Энэхүү судалгааны явцад бүртгэгдсэн тохиолдлуудаас цаана өшөө олон тохиолдол байхыг ч үгүйсгэхгүй байна.



Тухайлбал “Хурдан морь унаач хүүхдийн үндэсний чуулган”-ы насанд хүрэгсэдийн нээлттэй хэлэлцүүлэгт морин спортын холбооны ажилтан Батбадрах хийсэн илтгэлдээ хурдан морины уралдааны явцад сүүлийн жилүүдэд 9 хүүхэд эндсэн тухай дурьдсан бөгөөд тэдгээрийн зарим нь энэхүү судалгааны явцад бүртгэгдсэн тохиолдлуудаас өөр тохиолдлууд байсан. Эдгээр 9 тохиолдлыг дотор хурдан морины уян дээр хоёр ч хүүхэд моринд өшиглүүлснээс нас барсан тухай дурьдагдсан. Энэ нь морин уралдааны явцад хүүхэд эндсэн тохиолдол “17” гэсэн тоогоор хязгаарлагдахгүй болохыг харуулж байна.

Судалгааны явцад хийсэн дүгнэлтээс үзвэл морин уралдааны явцад хүүхэд мориноосоо унаж эндсэн тохиолдлуудыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж учир шалтгааныг тодруулж байсан тохиолдол байдаггүй болох нь харагдаж байна. Харин ч хурдан морины уралдааны явцад хүүхэд эндсэн, хүнд ноцтой гэмтэл авсан тохиолдлыг уяачид, эцэг, эхчүүд аль болох нууцалдаг, аль нэг байгууллагад мэдээлхээс аль болох зайлсхийдэг байдал ажиглагдсан байна. Ийм учраас хурдан морины уралдааны явцад хүүхэд эндсэн тохиолдлыг аль нэг байгууллагын мэдээ тайлангаас, баримт бичгээс харах, илрүүлэх боломжгүй байна.

Морин уралдааны явцад эндсэн хүүхдүүдийг насных нь ангиллаар авч үзэхэд:

- 5 настай - 1,
- 7 настай - 2,
- 9 настай - 3,
- 10 настай - 5,
- 11 настай - 1,
- 12 настай- 2,
- 13 настай – 3

хүүхэд тус тус байна. Насны энэхүү үзүүлэлтээс харахад хүүхдийн эндэгдэл бүх насны хүүхдүүдэд ижилхэн шахам бүртгэгдсэн байна. Түүнчлэн эдгээр тохиолдлууд нь бүх насны морин уралдааны явцад

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



бүртгэгдсэн байна. Даага уралдуулж байгаад эндсэн тохиолдол ч байна. Иймээс аль нэг насны тухайлбал азарга, их насны морьдын уралдааныг илүү аюултай гэж үзэх үзүүлэлт ажиглагдаагүй байна.

Эдгээр тохиолдлуудын зарим нь морин уралдааны зохион байгуулалтын буруутай үйл ажиллагаатай холбоотой гарч байна. Тухайлбал Сүхбаатар аймагт 2005 оны өвөл цасан шуургатай өдөр морин уралдаан зохион байгуулснаас, Төв аймгийн Баян суманд зурхайн олсонд морь нь орооцолдож унаснаас, Орхон аймагт морь нь замын хашлага шон мөргөснөөс шалтгаалж хүүхэд эндсэн байна. Бусад тохиолдлууд нь хүүхэд мориноосоо унаж эндсэн байна. Харин зарим тохиолдолд мориноосоо унаж дөрөө, жолоондоо чирэгдэх, морьтойгоо хамт унаж даруулах гэх мэт шалтгаантай байдаг байна. Амь эрсэдсэн хүүхдийн эцэг эх, төрөл төрөгсөд энэ асуудлыг эргэж ярих тайлбар өгөх сонирхол бага байдаг нь ажиглагдаж байна.

Хурдан морины уралдааны явцад хүүхэд эндсэн тохиолдлуудыг аймаг тус бүрээр нь дор харуулав.

1. Баянхонгор аймагт 2001 оны аймгийн баяр наадмын хурдан морины уралдааны үеэр морь нь үлийнд бүдэрснээс Эрдэнэцогт сумын харъяат 7 настай хүү мориноосоо унаж, тархиндаа хүнд гэмтэл авч, 2 хоноод нас барсан. Тархины хүнд гэмтэл авсан байсан байна.
2. Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт отрын малчид 2006 оны 2-р сарын 6-нд хурдан морины уралдаан зохион байгуулж 12 настай Б гэгч хүү өмнө нь их насны морь уралдаж, мориноосоо унаж, бэртэл авсан байсан ба үүнийгээ хэлээгүй дахин морь унаж, уралдааны замд ухаан алдаж мориноосоо унаж, эмнэлгийн тусламж үзүүлсэн боловч нас барсан байна. Хүний морь унаж байсан. Энэ уралдаанд 3 насны морь уралдсан, эмчийн ярьснаар эцэг нь загнаж байгаад дахин морь унуулсан, чи хүний морь унана гэхчээд унахгүй яахав гэсэн гэнэ. Мориныхоо

УИЧ МН  
СЭВАЛГААНЫ САН



хажууруу толгой нь унжиж доошилсоор байгаад унасан тухай морь дагасан хүмүүс ярьсан байна.

3. Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд 2005 оны 2-р сарын 18-нд цасан шуургатай байхад морь уралдуулсан байна. Морь унаж явсан 13 настай хүүхэд барианд орж ирээгүй байна, Эзэд нь морь хүүхдийг эрээд олоогүй бөгөөд маргааш нь хүүхэд мориноосоо унаж хөлдсөн байхыг олсон байна. Морь нь хадуурч явснаас цасан шуурганд төөрч хүүхэд хөлдөж нас барсан. Хүүхдийг маргааш өдөр нь олсон байна. Аймгийн цагдаагийн газраас тодруулахад ийм хэрэг огт шалгагдаагүй бүртгэгдээгүй байна. Харин орон нутгийн сонинд энэ тухай мэдээлэл гарсан байна.
4. Завхан аймгийн Яруу сумын ойгоор 2004 оны 7-р сарын 26-нд дааган насны морины уралдаанд 13 настай эрэгтэй хүүхэд даага нь үлийд бүдэрсний улмаас унаж явсан даага нь хүүхдээ дарж унасан ба эмнэлэгт хүргэгдсэн боловч эмчилгээ аваагүй, амь насыг нь аварч чадаагүй байна.
5. Говь - Алтай аймгийн Халиун суманд 2003 онд соёолон насны морь унаж байсан 7 настай эрэгтэй хүүхэд морь нь унаж мориндоо дарагдаж тархиндаа хүнд гэмтэл авсны улмаас нас барсан байна.
6. 2004 оны 10 сард тус аймгийн Говь - Алтай аймгийн Есөнбулаг суманд зохион байгуулагдсан бооцоот уралдааны явцад 10 настай эрэгтэй хүүхэд мориноосоо унаж, жолоондоо чирэгдэж нас барсан байна.
7. 2004 оны 6-р сарын 15-нд болсон Ховд аймгийн Дөргөн сумын Уламын овооны наадамд Захан аймгийн Дөрвөлжин сумын харьяат 10 орчим насны хүүхэд уралдааны замд мориноосоо унаж эмнэлэгт хүргэгдэн нас барсан байна.
8. Архангай аймгийн Булган суманд 1998 онд 9 настай эрэгтэй хүүхэд уралдааны явцад мориноосоо унаж нас барсан байна.

9. 2003 онд Дорнод аймгийн Матад суманд 5 настай хүүхдээрээ морь унуулж, эмээлтэй нь хүлж явуулж хүүхэд мориноосоо унаж нас барсан байна.
10. Орхон аймагт 2003 оны Даншиг наадамд соёолон морины уралдаанд 1, 2004 оны овоо тахилгын наадамд 1, 2005 оны Өндөр гэгээн Занабазарын ойгоор 1, 2005 оны тойргийн их насны морины уралдаанд 1 бүгд 4 хүүхэд нас барсан байна.
11. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын харьяат 9 настай эрэгтэй хүүхэд 2005 онд Төв аймгийн Баян сумын улсын баяр наадмын морины уралдаанд морьд гарааны зурхайгаас гарах үед морь нь татсан олсонд орооцолдож, морины комиссын буруугаас нас барсан, мөн аймгийн Цагаандэлгэр сумын харьяат 10 настай эрэгтэй хүүхэд уралдааны замд мориноосоо унаж нас барсан байна.
12. Говьсүмбэр аймагт 1996 онд бригадын ойгоор уралдааны үед нуранги үүсэж нурангид дарагдаж, 10 настай эрэгтэй хүүхэд нас барсан.

### **3.2. Хурдан морины уралданы явцад хүүхдийн биед учир буй гэмтэл, бэртлийн талаар**

Хурдан морины уралдааны явцад мориноосоо унах явдал багагүй гардаг талаар нилээд аймгийн тайланд тусгагдсан байна. Морин уралдаан зохион байгуулахад морьд гараанаас гарах үед хүүхдүүд мориноос их унадаг, энэ нь уралдаан зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой байдаг байна. Ялангуяа их хэмжээний морьд гарааны зурхайгаас гаргах ажил маш хүндрэлтэй байдаг талаар ярилцлаганд оролцогсод ярьсан байна.

2000 онд Архангай аймгийн Их тамир суманд зохион байгуулагдсан “Их хурд” морин уралдаанд 783 их насны морь, 407 азарга, 402 соёолон, 342 хязаалан, 344 шүдлэн, 283 даага тус тус уралдаж байсан байна.

Жилд дунджаар их бага хэмжээний 500 орчим морин уралдаан зохион байгуулагдаж 150.0 мянга орчим морь уралддаг гэж зарим эх сурвалжид дурьдсан байна. /Зууны мэдээ сонины 2006 оны 108 дугаарт нийтлэгдсэн нийтлэлээс/

Архангай аймгийн улсын баяр наадмын морины комиссын гишүүн эмч Авирмэд наадмын 6 насны морины уралдаанд ойролцоогоор 50 орчим хүүхэд мориноосоо унадаг, тэдний 15 - 20 орчим хувь нь гэмтэл авдаг гэж ярьсан байна.

Хурдан морь унаач хүүхдийн улсын чуулганд орлцсон 59 хүүхдийн дунд судалгаа хийж санал асуулга явуулахад тэдний 33.8 хувь нь морь уралдаж байхдаа мориноосоо унаж байсан гэж, 10.1 хувь нь бэртэл гэмтэл авч байсан гэж, 38.9 хувь нь өвлийн улиралд морь уралдах явцдаа хөл, гар, нүүрээ хөлдөөж хайруулж байсан гэж, 28.9 хувь нь хурдан морь уралдахад ядардаг гэж, 10 гаруй хувь нь хурдан морь унах үед айдас төрдөг гэж тус тус хариулсан байна.

Улсын баяр наадмаар нэг аймагт их насны морь 120, нэг суманд их насны морь 80 орчим уралддаг гэж тооцож үзвэл улсын хэмжээнд улсын баяр наадмаар багаар бодоход 30.0 мянга гаруй хүүхэд морь унаж, хэн ч тооцоолж болзошгүй эрсдэлд орж азаа сорьдог байна. Үүнийг 5 насны мориор бодож, бусад үед болдог олон зуун уралдааныг тооцож үзвэл 150.0 орчим мянган морь уралддаг гэсэн тоо үндэслэлгүй биш бололтой. Энэ тоон дээр уралдаанд бэлтгэх үсэргээ, сунгаанд орж уралдаж байгаа тоог нэмбэл жилд хэдэн зуун мянган удаа хүүхэд хурдны морь унадаг байна. Харин энэ олон зуун мянган тохиолдлоос хэдэн хүүхэд бие эрхтэндээ гэмтэл бэртэл авч хохирсныг нэгтгэн гаргасан анхаарлаа хандуулсан төрийн байгууллага байхгүй байна.

Хурдан морины уралдааны явцад бие эрхтэндээ гэмтэл, бэртэл авсан хүүхдийн тоог гаргах тойм судалгаагаар сүүлийн 3 жилд /2004-2006

онуудад/ 206 хүүхэд мориноосоо унах явцдаа гэмтэл бэртэл авсан гэж гарсан байна. Тэдний 39.8 хувь нь хөнгөн, 31.0 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд гэмтэл авсан байна. Хурдан мориноос унасан хүүхдүүд нь ихэвчлэн гар, хөл, тархи толгой, эгмэндээ гэмтэл бэртэл авдаг байна. Хүүхдэд учирсан гэмтэл бэртлийн 40.3 хувь нь гар, эгэм, мөрөндөө, 29.8 хувь нь тархи толгойндоо, 24.1 хувь нь хөл тулгуур эрхтэндээ гэмтэл авсан байна. Хурдан морины уралдаанд бэлтгэх, сунгааны үед ч хүүхдүүд бэртэл гэмтэл авдаг байна. Бэртэл гэмтэл авсан 206 хүүхдийн 91.8 хувь нь уралдааны үед, харин 9.2 хувь нь сунгааны үед мориноосоо унаж бэртэл гэмтэл авсан байна. Үүнээс харвал сунгааны үед хүүхэд мориноосоо унаж бэртэх нь харьцангуй цөөн байдаг гэж үзэж болохоор байна.

Зарим аймгийн судалгааны тайланд хурдан морих унах явцдаа мориноосоо унаж, эрүүл мэнд нь ноцтой хохирч, тахир дутуу болсон баримт тэмдэглэгдсэн байна.

Тухайлбал Өвөрхангай аймагт 2004 онд зохион байгуулагдсан уралдаанд 12 настай эмэгтэй хүүхэд мориноосоо унаж, түнх, булууны яс нь хугарч, хөлгүй болж, байнгын тахир дутуу болсон бөгөөд эмчилгээний зардал байхгүйгээс гадаадад явж эмчлүүлж чадахгүй байгаа ба эмчилгээний зардал олох талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүсэлт тавьсан байна.

Төв аймагт 2005 оны их насны морины уралдаанд 8 настай хүүхэд мориноосоо унаж, тархи нуруундаа гэмтэл авч суумгай болсон, мөн дааганы уралдаанд 10 настай эрэгтэй хүүхэд мориноосоо унаж, тархиндаа мэс засал хийлгэж явж чадахгүй болсон байна.


Түүнчлэн сүүлийн жилүүдэд өвөл цагт, хүйтэн сэрүүн нөхцөлд морь уралдах болсноос хүүхэд уралдааны явцад бие эрхтэнээ хөлдөөх явдал гарах болсон байна. 2006 оны 2-р сард Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд их нас, соёолон уралдуулсан ба энэ уралдааны явцад 2-р ангийн хүүхэд хөлөө хөлдөөж одоо удаан зогсож чадахаа болсон хөлдөц нь арилаагүй байна.

2006 оны 2-р сарын эхээр уяачдын холбооноос зохион байгуулсан хурдан морины уралдааны үеэр 30 орчим хэмийн хүйтэнтэй байсан ба олон хүүхэд хөл, гар, хацараа хөлдөөсөн тухай мэдээлэл байна. Хурдан морины уралдааны үед эмнэлгийн түргэн тусламжийн машин явдаг хэдий ч уралдааны явцад гарсан осол гэмтлийг нарийвчлан бүртгэж баталгаажуулдаггүй, холбогдох газарт нь мэдээлдэггүй байна.

Хурдан морь унаач хүүхдийн үндэсний чуулганд оролцсон 120 орчим хүүхдэд эмнэлгийн үзлэг хийхэд 30 гаруй хувь нь бөөрний үрэвсэлтэй, 20.0 хувь нь элэгний үрэвсэлтэй, ихэнхи нь нүүрэндээ шарх сорвитой байсан байна.

Эдгээр тоо баримт нь хурдан морь унаач хүүхдүүд ямар их эрсдэл дунд байдгийг гэрчилнэ. Түүнчлэн олон жил хурдан морь унах нь хүүхдийн эрүүл, саруул, зөв өсөж хөгжихөд ямар нөлөө үзүүлдэг болохыг шинжлэх ухааны үүднээс судалсан, ажиглалт хийсэн тохиолдол байхгүй байна. Гэтэл зарим уяачид, морь сонирхогчид хүүхдээр морь уралдуулах нь тэднийг тэсвэр хатуужилтай, ухаантай болгодог, эрүүл мэндэд нь сөрөг нөлөө үзүүлдэггүй, харин ч эерэг нөлөө үзүүлдэг хэмээн тайлбарлаж байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 32-р зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхэд эдийн засгийн мөлжлөгөөс болон түүний эрүүл мэндэд хор аюул учруулах буюу боловсрол олоход нь саад болох эсвэл түүний эрүүл мэндэд болон бие бялдар, оюун ухаан, ёс суртахууны хийгээд нийгмийн хөгжилд хор уршиг учруулж болзошгүй аливаа ажил эрхлэхээс хамгаалагдах эрхтэйг орлцогч улсууд хүлээн зөвшөөрнө” гэж заасан байна. Судалгааны дүн нь хүүхдээр хурдны морь унуулах нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэл дагуулдаг болохыг илтгэн харуулж байна. Иймээс хүүхдээр хурдны морь унуулах тухай асуудлын төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, оновчтой зохицуулалт хийхийг бодит байдал харуулж байна.



Хурдан морины уралдааны явцад мориноос унаж бэртэл, гэмтэл авсан хүүхдийн судалгааг аймгуудаар гаргаж дор дурьдсан хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1.

№	Аймаг	Хурдан морь унадаг хүүхдийн тоо /эмэгтэй/	бэртсэн хүүхдийн тоо /эмэгтэй/	Үүнээс гэмтлийн зэргээр			Амь эрсдсэн хүүхдийн тоо	Гараа хугалсан	Хөлөө хугалсан	Эгэмээ хугалсан	Тархиндаа гэмтэл авсан	Тахир дутуу болсон	Сунгааны явцад гарсан	Уралдааны явцад гэмтэл авсан
				Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд								
1.	Архангай	279/6	34/3	1 5	12	6	1	20	4	1	2		8	26
2.	Баян-Өлгий		14	1 1	1	2					3			
3.	Баянхонгор	400	4		2	1	1	1	1					4
4.	Булган	588	5	1	4		1	2					1	4
5.	Говь-Алтай	2151	12	1 1		3	1	2	1		2			12
6.	Говьсүмбэр	131/18	15	3	5	6	1	1	3	1	5		1	14
7.	Дархан-Уул													
8.	Дорноговь	-	-	-	-		-							
9.	Дорнод	1648	16/3	6	5	4	1	3	4	1	3		1	15
10.	Дундговь	200	8		3	3	2	3	1		2			8
11.	Завхан	784/17	4		1	2	1	1	1		2			4
12.	Орхон	209	15	2	5	3	4	2	4		3		2	13
13.	Өвөрхангай													
14.	Өмнөговь		4	2	2			2			1			
15.	Сүхбаатар	250	6	3	1	1	1	1	1		1			6
16.	Сэлэнгэ	664	6	6							6			6
17.	Төв	380	12	3	1	6	2	1	2		4			10
18.	Увс		13/3	2	9	2		5	2			1		
19.	Ховд	410	9	1	7		1	2	3				1	8
20.	Хөвсгөл	1200	11	7	3	1		2		4			2	9
21.	Хэнтий		12/2	9	3			2	3		3		1	8
<b>Нийт дүн</b>			<b>206/11</b>	<b>82</b>	<b>64</b>	<b>43</b>	<b>17</b>	<b>50</b>	<b>30</b>	<b>7</b>	<b>37</b>	<b>1</b>	<b>19</b>	<b>187</b>



### 3.3. Хурдан морины хүүхдийн хамгаалалтын хувцас, даатгалын талаар:

Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрмээр хурдан морины хүүхэд нь хамгаалалтын малгай, цээживч, өвдөг тохойн хамгаалалт, тусгай эмээлтэй байна гэж заасан боловч хамгаалалтын хувцас хэрэглэж хэвших явдал маш хангалтгүй байгаа нь судалгааны явцад харагдсан байсан. Ялангуяа энэ асуудал хөдөө орон нутагт ор нэрийн төдий байна.

Хурдан морь унаач хүүхдийн чуулганд орлцсон хүүхдүүдээс санал асуулгаар судалгаа авч үзэхэд 44.0 хувь нь морио зайдан /эмээлгүй/ унадаг гэж, дийлэнхи олонхи нь хамгаалалтын хувцас шаардлагатай байдаг гэж хариулсан байна.

Хамгаалалтын хувцас хэмээн эдгээр зүйлүүдийг дүрмэнд нэрлэсэн ч эдгээр хувцас нь ямар загвар стандарт, хэмжээтэй байх нь тодорхой биш байгаа учраас ямар зүйлийг хамгаалалтын хувцас гэж үзэх нь ч хүндрэлтэй байна. Иймд хамгаалалтын хувцасны талаар судалгаа явуулж, ямар төрлийн, ямар үзүүлэлттэй хамгаалалтын хувцас хэрэглэхийг ч нарийвчлан тогтоох хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэгчид өөрсдөө санаачлага гаргаж, эмээл, дөрөө, малгай зэрэг зүйлийг хийж, гаднаас зарим хэрэглэлийг оруулж ирж байгаа боловч үнийн хувьд харьцангуй өндөр байна. Иймд хамгаалалтын хувцас үйлдвэрлэх, нийлүүлэх асуудлыг төрөөс дэмжих хөгжүүлэх асуудал шаардлагатай байна.

Хурдан морины хүүхдийг гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байхаар хуульд тусгайлан заасан ч хэрэгжилт нь төдийлэн сайн биш байна. Хурдан морины уралдаанд орох морьдыг бүртгэхдээ даатгалын баталгаа байхгүй тохиолдолд уг морийг бүртгэхээс татгалзах ёстой ч ингэж чаддаггүй байна. Гэхдээ бүх аймгууд хурдан морины хүүхдийг 100 хувь биш юмаа гэхэд ямар нэгэн хэмжээгээр гэнэтийн ослын даатгалд даатгуулдаг болсон байна.


Судалгааны байдлаас ажиглавал хурдан морины хүүхдийг гэнэтийн ослын даатгалд даатгуулах ажил улсын болон аймгийн чанартай уралдаанд



харьцангуй сайн, харин сум болон жижиг морин уралдааны явцад харьцангуй муу байдаг байна. Хурдан морины хүүхдийг ихэвчлэн 500 мянган төгрөгөөр үнэлж, даатгалын хураамжид 3500 төгрөг төлдөг байна. Даатгалд хамрагдсан хүүхдүүдээс мориноосоо унаж бэртэж гэмтэл авсан хүүхдүүд ихэвчлэн 10 - 50,60 мянган төгрөгний нөхөн төлбөр авсан байна. Цөөн тохиолдолд 100 мянга орчим төгрөг авсан байна. Зарим орон нутагт хийгдсэн судалгааны явцад даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг олон компани ажиллаж даатгалын гэрээ байгуулдаг хэдий ч эргээд нөхөн төлбөр авах болоход даатгалын компани нь хаана байгаа нь мэдэгддэггүй, олддоггүй гэсэн шүүмжлэл гарч байсан байна. Даатгуулагч осол гэмтэлд орж нөхөн төлбөр авдаг хэдий ч тэр нь эрүүл мэндээ нөхөн сэргээхэд хүрэлцдэггүй байна. Иймээс эрүүл мэндээрээ ноцтой хохирсон хүүхдүүд нэмэлт эх үүсвэр хайх шаардлагатай болдог байна.

#### **3.4. Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийн хөлс үнэлгээний талаар:**

Хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах асуудал хурдан морины уралдааны анхаарал татсан, нэг мөр журамлагдаагүй асуудал болох нь харагдаж байна. Монгол улсын Засгийн газраас баталсан хурдан морины уралдааны дүрмийн 9-р зүйлд түрүүлсэн, айрагдсан морины бай шагналын 20 хувь нь хурдан морь унаач хүүхдэд оногдоно гэж заасан байна. Харин морь нь түрүүлээгүй, айрагдаагүй /бариад орсон, ороогүй/ тохиолдолд ямар шагнал олгох нь тодорхой биш байна. Үүнээс өөр хурдан морь унаач хүүхдийн хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах талаар зохицуулалт байхгүй байна. Хурдан морь унаач хүүхэд нь хурдан морины уралдаанд бэлтгэх, оролцоход ихээхэн цаг, хүүхдэд зарцуулдаг байна. Судалгааны явцад ярилцлага өгсөн зарим хүүхдүүд өвөл, хавар, намрын уралдаанд 3-7 хоног, баяр наадам зэрэг том уралдаанд 1 сар гаруй хугацаагаар бэлтгэх тохиолдол байдаг тухай ярьжээ.



Хурдан морь унаач хүүхэд нь уралдаанд бэлтгэж олон хоног хөдөлмөрлөж, хичээл номноосоо нилээд хөндийрдөг байна. Хурдан морь унаач хүүхэд нь уралдаанд бэлтгэх явцад морь хөлслөх, хөдөлгөх, баалгаж шээлгэх, зогсоол цэвэрлэх, морь өвслүүлэх услах зэрэг олон төрлийн ажилд оролцдог байна.

Хурдан морь унаач хүүхдүүд ихэвчлэн хувцас, хичээлийн хэрэгсэл, цөөн тооны /3, 5,10 мянга/ мөнгө авдаг гэж ариулсан байна. Зарим уяачид хурдан морины хүүхэддээ морь, мал өгдөг тухай тэмдэглэгдсэн байна.

2005 онд Хөвсгөл аймгийн улсын баяр наадмаар Улаан-уул сумын уяач Ч-ийн 5 насны морийг унаж уралдуулж, 3 насны морь нь түрүүлж, 2 насны морь нь айрагдсан унаач хүүхэд 100.0 мянган төгрөгийн шагнал авч байсан байна.

Хурдан морь унаач хүүхдийн чуулганд оролцсон хүүхдийн дунд явуулсан санал асуулгаар хурдан морь унасны төлөө авч байгаа хөлс урамшуулалдаа сэтгэл ханамжтай байдаг уу гэж асуухад 80 орчим хувь нь тийм гэж, 20 орчим хувь нь үгүй гэж, 13 хүүхэд адуу мал, 11 хүүхэд электрон бараа, 9 хүүхэд хувцас, 2 хүүхэд мотоцикл, 3 хүүхэд хичээлийн хэрэгсэл авч байсан хэмээн хариулсан байна. Эдгээр хүүхдүүд нь ихэвчлэн олон жил морь унасан, унасан морь нь сайн давхиж байсан үзүүлэлт сайтай хүүхдүүд байсан тул хөлс урамшууллын хувьд харьцангуй сайн хариулт өгсөн гэж үзсэн.

Сүүлийн жилүүдэд зарим алдартай уяачид хүний өөрийн олон тооны морь уяж, өвөл зунгүй отог, гал хэлбэрээр байрлаж, ихэвчлэн амьжиргаа муутай айл өрхийн хүүхдийг цуглуулж, гол зогоох төдий хоол өгч, элдэв ажил төрөлдөө зарж, дорвитой хөлс хөдөлмөр өгдөггүй, хурдан морины уралдааны явцад уралдаан зохион байгуулагчид хүүхдүүдтэй хатуу ширүүн харьцдаг, чулуу модоор цохьдог гэсэн мэдээлэлийг ярилцлагад хамрагдсан зарим хүн хэлсэн байна. Эдгээр гал, отог нь хөндлөнгийн хяналт оролцооноос ч хол хөндий байдаг гэсэн байна.

### **3.5. Судалгаанаас хийсэн дүгнэлт**

Хурдан морь унаач хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар тойм судалгааг хийсэн нь анхны гэж хэлж болох бөгөөд цаашид судалгааг явуулахад юу анхаарах, яаж хийх талаар төсөөлөл өгсөн нь ач холбогдолтой боллоо. Цаашид хийгдэх судалгааг морин уралдаанд бэлтгэх, болон уралдаан зохион байгуулах явцад нь газар дээр нь хийх нь илүү ач холбогдолтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Судалгааны дүнгээс харвал хүүхдээр хурдан морь уралдуулах нь хүүхдийн амь нас, эрүүл мэндэд бодит эрсдэл дагуулж байдаг, ийм эрсдэл тогтмол гарч байдаг гэсэн дүгнэлтэнд хүрч байна. Иймээс хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зүгээс хүүхдээр хурдны морь унуулхыг аль болох хязгаарлах, унуулсан тохиолдолд эрсдэлээс хамгаалах арга хэмжээг сайтар зохион байгуулах, эрсдэл гарсан тохиолдолд эрүүл мэндийг нь бүрэн нөхөн сэргээх оновчтой механизмыг бий болгох нь зүйтэй гэж дүгнэж байна.

Хурдан морины уралдааны явцад хүүхэд мориноос унаж амь насаа алдах, бие эрхтэндээ гэмтэл согог авах, улмаар тахир дутуу болох зэрэг хүүхдийн эрхийн зөрчил гарсаар байна. Хурдан морь уралдуулах нь Монгол үндэстний баярлаж, цэнгэж байгаагийн нэг хэлбэр бөгөөд энэхүү цэнгээний золиос нь хүүхдүүд болж байна. Энэ үүднээс авч үзвэл хүүхдийн эрхийн энэхүү ноцтой зөрчилд төрийн зүгээс анхаарлаа хандуулахгүй байж болохгүй. Хамгийн ноцтой нь сүүлийн жилүүдэд морин уралдаан зохион байгуулах явдал улам бүр өсөж, нэг уралдаанд уралдах морьдын тоо хэдэн зуугаар тоологдох болсон. Иймээс хүүхдийн хамгааллын тухай асуудал онцгой байр суурийг эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд төрийн зүгээс хурдан морины уралдааныг зохион байгуулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зарим алхмуудыг хийсэн ч энэ нь нийтлэг шинж чанартай болж чадаагүй байна. Хуулийн зарим зохицуулалтыг ч харж үзэх шаардлагатай байна. Тухайлбал хурдны морь унаж болох хүүхдийн насны доод хязгаар, морин уралдаан зохион байгуулж болохгүй цаг хугацаа зэрэг нь амьдралд тэр бүр нийцэхгүй байна. Иймээс морин уралдаан зохион байгуулах журмын тухай хууль гаргаж, энэ

хуулиар морин уралдаан зохион байгуулах зөвшөөрөл олгохоос эхлээд хүүхдийн хамгааллын асуудлаар олон зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог иж бүрнээр нь шийдэх явдал чухал байна. Хурдны морь унаж буй хүүхэд мориноосоо унаж гэмтэх нь олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Эдгээрээс дурьдвал:

- Морь уралдаж буй байгаль цаг уурын байдал. Агаарын температур, салхи шуурга, цас, бороо гэх мэт байгалийн үзэгдлүүд.
- Хурдан морь уралдаж буй замын байдал маш их нөлөөлж байна. Уралдааны зам нь үлийтэй, жалга судагтай, гол горхи бартаатай байх нь хүүхэд мориноосоо унахад ихээр нөлөөлдөг байна.
- Уналага эдэлгээнд цагаашраагүй морь, морь уралдуулах чадвар муутай хүүхдийг уралдаанд оролцуулах зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Хурдан морины хүүхдийг хамгаалалтын хэрэгслээр хангахгүй, түүнийг хэрэглэж хэвшихгүй байгаа нь нөлөөлж байна. Хурдан морины хүүхдийн эрхийн тухай асуудлыг хөндөж ярихад зарим уяачдын холбоод, уяачид ихээхэн эмзэглэж, Монголын өв, уламжлал, зан заншилыг устгах гэсэн гаднын нөлөөлөл, хүүхэд хурдан морь унаснаар хэрсүүжиж, бие бялдрын хүмүүжил олдог гэж үзэх нь ч байна. Энэ бол нийгмийн массын санал бодол биш бөгөөд морь сонирхогч, уяач цөөн хүмүүсийн санал бодол гэж үзэж байна. Иймээс бага балчир хүүхдээрээ хурдан морь унуулах нь хир зөв эсэх, энэ нь хөхиүлэн дэмжих зан үйл мөн эсэх, хурдны морь уралдуулах нь хүүхдийн өсөлт хөгжилт, эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлж байгааг судлах нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрэв.

### **3.6. Санал , зөдлөмж:**

1. Хурдан морины уралдаан зохион байгуулах явдал өргөн дэлгэр болж, олон шалтаг шалтгаанаар морь уралдуулдаг болж, жил олон мянган хүүхэд морь уралдуулж байгаад дүгнэлт хийж, морин уралдаан зохион байгуулах журмын тухай нэгдсэн хууль гаргах нь зүйтэй. Энэ хуулиар аливаа морин уралдаан зохион байгуулахдаа тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагаас зохих зөвшөөрлийг авдаг журам тогтоох,
2. Хурдан морины уралдаан зохион байгуулж үл болох цаг хугацааны болон байгаль цаг уурын үзэгдлийн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох.
3. Хурдан морь унаж болох хүүхдийн нас, бие, эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг бий болгох.
4. Морь уралдуулах зам харгуйд тавигдах шаардлага үзүүлэлтийг боловсруулж мөрдөх. Үлийтэй, хадтай, жалгатай, гол горхитой, мөстэй газар морь уралдуулахыг хориглох.
5. Хурдан морины уралдааны явцад зохион байгуулагдах эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний журам, стандартыг батлан гаргаж, ийм үйлчилгээг хангаагүй уралдааныг хориглох, уралдааны явцад гарсан осол зөрчлийг судлан бүртгэх хянах тогтолцоо бий болгох.
6. Хурдан морины хүүхдийн бие хамгаалах хэрэгслийн жагсаалт, стандартыг бий болгох, ийм хэрэгслээр хангах, түүнийг үйлдвэрлэх нийлүүлэх ажлыг төрөөс дэмжих.
7. Хурдан морь унаач хүүхдийг ослын даатгалд даатгуулах, нөхөн төлбөр олгох харилцааг боловсронгуй болгох, шаардлагыг өндөржүүлэх, эрүүл мэндийг нь нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг гэм буруутай этгээдээр бүрэн нөхөн төлүүлэх тогтолцоог бий болгох.
8. Хурдан морь унаач хүүхдүүдэд ур чадварыг нь дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулдаг болох.

**“ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ЧУУЛГАН”-Ы ТӨЛӨӨЛӨГЧ ХҮҮХДҮҮДЭЭС АВСАН  
АСУУМЖИЙН НЭГТГЭЛ**

№	Асуулт	Хариулт			
		Эр	Эм		
1.	Хүйс	<b>46</b>	<b>13</b>		
2.	Нас	7 хүртэл	7- 8	7-оос дээш	
				<b>59</b>	
3.	Ам бүлийн тоо	4 хүртэл	4 – 5 хооронд	5-аас дээш	
		<b>12</b>	<b>25</b>	<b>21</b>	
4.	Хурдан морины уралдаанд оролцож эхэлсэн нас	3 – 4 хооронд	5- 6 хооронд	7 - оос дээш	
		<b>8</b>	<b>25</b>	<b>25</b>	
5.	Уралдаж явахдаа мориноос ойчиж байсан эсэх	Тийм			Үгүй
		1 удаа	2 – 3 удаа	3-аас дээш	
		<b>16</b>	<b>2</b>	<b>2</b>	<b>38</b>
6.	Уралдах явцдаа ямар нэгэн бэртэл гэмтэл авч байсан эсэх	Тийм			Үгүй
		<b>6</b>			<b>52</b>
7.	Өвлийн улиралд уралдаанд уралдаж байсан эсэх	Тийм		Үгүй	
		<b>47</b>		<b>11</b>	
	Өвлийн улиралд морины уралдаанд нүүр гар хөлдөх зэрэг бэрхшээл гарч байсан уу	Тийм			Үгүй
		<b>23</b>			<b>35</b>

УИХ-ЫН  
СЭДАЛГААНЫ САН



8.	Уралдааны үед ямар нэг айдас төрдөг үү	Айдаг				Айдаггүй	
		7				51	
9.	Морь унасныхаа төлөө мөнгө авч байсан уу	Тийм				Үгүй	
		49				9	
10.	Тийм бол хамгийн их нь хэдэн төгрөг авч байсан бэ	1 000-10 000₮	10000-30000₮		30000-50000₮	50000₮ дээш	
		14	16		10	9	
11.	Шан урамшуулалдаа сэтгэл ханамжтай байдаг уу	Тийм		Үгүй		Хариулаагүй	
		41		7		10	
12.	Мөнгөнөөс өөр шан урамшуулал авдаг уу	Тийм				Үгүй	
		41				17	
13.	Мөнгөнөөс өөр юм авч байсан бол юу авч байсан бэ	Электрон бараа	Мотоцикл	Адуу мал	Хувцас	Хичээлийн хэрэгсэл	Чихэр, боов
		11	2	13	9	3	3
14.	Морио эмээлтэй унадаг уу	Эмээлтэй		Зайдан		Аль аль нь	
		24		26		8	
15.	Нэг баяр наадмаар хэдэн насны морь унадаг вэ	1 – 2 насны		3 – 4 насны		5—6 насны	
		3		27		28	
16.	Морь унаж уралдах шийдвэрээ өөрөө гаргадаг уу	Тийм				Үгүй	
		39				19	
17.	Хэзэв үгүй бол хэн гаргадаг вэ	Эцэг эх				Уяач	
		15				4	
18.	Морь унах үедээ ядардаг уу	Тийм				Үгүй	
		17				41	
19.	Загнуулж, зодуулах зэрэг шийтгэдэг үү	Тийм				Үгүй	
		4				54	
20.	Морь унахад ямар хувцас, хамгаалалт тохиромжтой вэ	Өвөл				Зун	
		Дулаан, хөнгөн, салхи нэвтэрдэггүй				Хөлс, бороо, салхи нэвтрэхгүй	



		хувцас, комбинзон, үстэй дээл, эсгий гутал, малгай, тохойн болон өвдөгний хамгаалалт	гялгар материалтай нимгэн, хөнгөн хувцас, малгай, тохойн болон өвдөгний хамгаалалт
--	--	--	--

Хурдан морины уралдааны явцад мориноосоо унаж  
амь эрсэдсэн хүүхдийн судалгаа

1. Баянхонгор аймагт 2001 оны аймгийн наадмын хурдан морины уралдааны үеэр морь нь үлийнд бүдэрснээс Эрдэнэцогт сумын харъяат 7 настай хүү мориноосоо унаж, тархиндаа гэмтэл авч, бариачид бариулаад, 2 хоноод нас барсан. Тархины хүнд гэмтэл авсан байсан байна.
2. Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт отрын малчид 2006 оны 2-р сарын 6-нд хурдан морины уралдаан зохион байгуулж 12 настай Б гэгч хүү өмнө нь их насны морь уралдаж, мориноосоо унаж, бэртэл авсан байсан ба үүнийгээ хэлээгүй дахин морь унаж, уралдааны замд ухаан алдаж мориноосоо унаж, эмнэлгийн тусламж үзүүлсэн боловч нас барсан байна. Хүний морь унаж байсан. Энэ уралдаанд 3 насны морь уралдсан, эмчийн ярьснаар эцэг нь загнаж байгаад дахин морь унуулсан, чи хүний морь унана гэхчээд унахгүй яахав гэсэн гэнэ. Мориныхоо хажууруу толгой нь унжиж доошилсоор байгаад унасан тухай морь дагасан хүмүүс ярьсан байна.
  - Сүхбаатар суманд 2005 оны 2-р сарын 18-нд цасан шуургатай байхад морь уралдуулсан байна. Морь унаж явсан 13 настай хүүхэд барианд орж ирээгүй байна, Эзэд нь морь хүүхдийг эрээд олоогүй бөгөөд маргааш нь хүүхэд мориноосоо унаж хөлдсөн байхыг олсон байна. Морь нь хадуурч явснаас цасан шуурганд төөрч хүүхэд хөлдөж нас барсан. Хүүхдийг маргааш өдөр нь олсон байна. Аймгийн цагдаагийн газраас тодруулахад ийм хэрэг огт шалгагдаагүй бүртгэгдээгүй байна. Харин орон нутгийн сонинд энэ тухай мэдээлэл гарсан байна.
3. Завхан аймгийн Яруу сумын ойгоор 2004 оны 7-р сарын 26-нд дааган насны морины уралдаанд 13 настай эрэгтэй хүүхэд даага нь үлийд бүдэрсний улмаас унаж явсан даага нь хүүхдээ дарж унасан ба эмнэлэгт хүргэгдсэн боловч эмчилгээ аваагүй, амь насыг нь аварч чадаагүй байна.
4. Говьалтай аймгийн Халиун суманд 2003 онд соёолон насны морь унаж байсан 7 настай эрэгтэй хүүхэд морь нь унаж мориндоо дарагдаж тархиндаа хүнд гэмтэл авсны улмаас нас барсан байна.
  - 2004 оны 10 сард тус аймгийн есөнбулаг суманд зохион байгуулагдсан бооцоот уралдааны 10 настай эрэгтэй хүүхэд мориноосоо унаж, жолоондоо чирэгдэж нас барсан байна. Эдгээр хэргүүд нь хуулийн байгууллагаар шалгагдаагүй байна.
5. 2005 оны улсын баяр наадмын Баян сумын уралдаанд 10 орчим насны эрэгтэй хүүхэд мориноосоо унаж, 2006 онд тус аймгийн

- Дэлгэрхаан сумын бооцоот уралдаанд нэг эрэгтэй хүүхэд мориноосоо унаж нас барсан байна.
6. 2004 оны 6-р сарын 15-нд болсон Ховд аймгийн Дөргөн сумын Уламын овооны наадамд Захан аймгийн Дөрвөлжин сумын харьяат 10 орчим насны хүүхэд уралдааны замд мориноосоо унаж эмнэлэгт хүргэгдэн нас барсан байна.
  7. Архангай аймгийн Булган суманд 1998 онд 9 настай эрэгтэй хүүхэд уралдааны явцад мориноосоо унаж нас барсан байна.
  8. 2003 онд Дорнод аймгийн Матад суманд 5 настай хүүхдээрээ морь унуулж, эмээлтэй нь хүлж явуулж хүүхэд мориноосоо унаж нас барсан байна.
  9. Орхон аймагт 2003 оны Даншиг наадамд соёолон морины уралдаанд 1, 2004 оны овоо тахилгын наадамд 1, 2005 оны Өндөр гэгээн Занабазарын ойгоор 1, 2005 оны тойргийн их насны морины уралдаанд 1 бүгд 4 хүүхэд нас барсан байна.
  10. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын харьяат 9 настай эрэгтэй хүүхэд 2005 онд Төв аймгийн Баян сумын улсын баяр наадмын морины уралдаанд морьд гарааны зурхайгаас гарах үед морь нь татсан олсонд орооцолдож, морины комиссын буруугаас нас барсан, мөн аймгийн Цагаандэлгэр сумын харьяат 10 настай эрэгтэй хүүхэд уралдааны замд мориноосоо унаж нас барсан байна.
  11. Говьсүмбэр аймагт 1996 онд бригадын ойгоор уралдааны үед нуранги үүсэж нурангид дарагдаж, 10 настай эрэгтэй хүүхэд нас барсан.  
Хурдан морины уралдааны явцад гарч буй хүүхдийн эрхийн судалгаагаар сүүлийн жилүүдэд 17 хүүхэд морин уралдааны явцад мориноосоо унаж нас барсан байна. Эдгээр 17 тохиолдлын нэгээс бусад нь 2000 оноос хойш болсон морин уралдааны явцад гарсан байна. Судалгааны явцад хийсэн дүгнэлтээс үзвэл морин уралдааны явцад мориноосоо унаж бэртэж нас барсан тохиолдлуудыг хууль хяналтын байгууллагаар шалгуулж, эрүгийн хэрэг үүсэгсэн тохиолдол бараг байдаггүй байна. Харин хурдан морины уралдааны явцад хүүхэд амь нас нь хохирсон тохиолдлыг нууцалдаг, энэ тэнд мэдээлхээс аль болох зайлсхийдэг байдал ажиглагдсан байна. 2005 онд Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд болсон, 1998 онд орнод аймагт болсон харамсалтай тохиолдлууд нь уралдаан зохион байгуулагчид, эцэг эхийн шууд буруутай ажиллагаатай холбоотой байна. Морин уралдааны явц дахь хүүхдийн амь нас эрсэдсэн тохиолдлууд нь аливаа газар бүртгэгддэггүй, мэдээлэгддэггүй учир шалтгаан нөхцлийг нь нарийвчлан судлах, нарийвчилсан мэдээлэл авах, олох боломж маш хомс байдаг байна. Амь эрсэдсэн хүүхдийн эцэг эх, төрөл төрөгсөд энэ асуудлыг эргэж ярих тайлбар өгөх сонирхол бага байдаг нь ажиглагдаж байна.  
Эдгээр амь эрсэдсэн тохиолдлууд нь бүгд эрэгтэй хүүхэд байсан ба насны ангиллаар авч үзэхэд 5 настай 1, 7 настай 2, 9 настай 3, 10 настай 5, 11 настай 1, 12 настай 2, 13 настай 3 хүүхэд байна. Эдгээр тоо

баримтыг улсын хэмжээнд бүрэн гүйцэт гарсан тоо гэж хэлэхэд учир дутагдалтай. Судалгааг богино хугацаанд хийсэн учир хөдөө орон нутгаас бүрэн гүйцэт мэдээлэл цуглаагүй гэж үзэх үндэстэй. Энэ тоо бол бага биш тоо. Морин уралдаан нь Монголын уламжлалт баяр наадмын цэнгээний нэг хэлбэрч үүний улмаас гэмзэмгүй олон хүүхэд амь насаараа хохирно гэдэг нь хүүхдийн эрхийн ноцтой зөрчил гэж үзэхээс өөр аргагүй юм.

**Хурдан морины уралдааны явцад мориноосоо унаж бэртэл, гэмтэл авсан хүүхдийн судалгаа**

Д/д	Аймаг	Хурдан морь унадаг хүүхдийн тоо /эмэгтэй/	Мориноос унаж бэртсэн хүүхдийн тоо /эмэгтэй/	Үүнээс гэмтлийн зэргээр			Амь эрсдсэн хүүхдийн тоо	Гараа хугалсан	Хөлөө хугалсан	Эгэмээ хугалсан	Тархиндаа гэмтэл авсан	Тахир дутуу болсон	Уралдаанд бэлтгэх явцад гэмтэл авсан	Уралдааны явцад гэмтэл авсан
				Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд								
1	Архангай	279/6	34/3	15	12	6	1	20	4	1	2		8	26
2	Баян-Өлгий		14/	11	1	2					3			
3	Баянхонгор	400	4		2	1	1	1	1					4
4	Булган	588	5	1	4		1	2					1	4
5	Говь-Алтай	2151	12	11		3	1	2	1		2			12
6	Говьсүмбэр	131/18	15	3	5	6	1	1	3	1	5		1	14
7	Дархан-Уул													
8	Дорноговь	-	-	-	-		-							
9	Дорнод	1648	16/3	6	5	4	1	3	4	1	3		1	15
10	Дундговь	200	8		3	3	2	3	1		2			8
11	Завхан	784/17	4		1	2	1	1	1		2			4
12	Орхон	209	15	2	5	3	4	2	4		3		2	13
13	Өвөрхангай													
14	Өмнөговь		4	2	2			2			1			
15	Сүхбаатар	250	6	3	1	1	1	1	1		1			6
16	Сэлэнгэ	664	6	6							6			6

УИМН  
СУДАЛГААНЫ САН

17	Төв	380	12	3	1	6	2	1	2		4		2	10
18	Увс		13/3	2	9	2		5	2			1		
19	Ховд	410	9	1	7		1	2	3				1	8
20	Хөвсгөл	1200	11	7	3	1		2		4			2	9
21	Хэнтий		12/2	9	3			2	3		3		1	8
<b>Нийт дүн</b>			206	82	64	43	17	50	30	7	37	1	19	187

Судалгааны дүнг нэгтгэсэн



Ж.Дашдорж

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ХҮҮХДИЙН ЭРХ БА ХӨДӨЛМӨР ХЭҮК

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүрэгтэй үндэсний байгууллага юм.

Хүүхдийн эрхийн тухай асуудал тус Комиссын үйл ажиллагаанд чухал байр суурь эзэлдэг. Тус Комисс энэ чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, шалтгалт судалгаа хийх, холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж, шаардлага илгээх зэргээр идэвхтэй ажиллаж ирсэн.

Комиссын тухай хуульд зааснаар Комисс нь жил болгон Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаархи илтгэлийг боловсруулж, УИХ-д өргөн барьдаг. Комиссын эхний хоёр удаагийн илтгэлд хүүхдийн эрхийн тухай асуудал тодорхой хэмжээгээр тусгагдсан бөгөөд 2003 оны 12 дугаар сард УИХ-ын Хууль зүйн байнгын хороо Комиссын хоёрдугаар илтгэлийг авч хэлэлцэн илтгэлд тусгасан асуудлууд, санал зөвлөмжийг сайшааж холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудад тодорхой чиглэл өгч, нөхцөл байдлыг сайжруулах талаар тогтоол гаргасан.

### **Хүүхдийн эрхийн талаар**

Хүүхдийн эрхийн тухай асуудал бол хүний эрхийн салшгүй нэг хэсэг юм. Өнөөдөр зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилт тулгараад байна. Хүүхдэд ээлтэй орчин нь эдийн засаг, хүн ам зүйн болон нийгэм, соёлын гэх мэт төрөл бүрийн хүчин зүйлүүдийг багтаасан гэр бүлийн нөхцөл, тухайлбал, тохьтой байр, хүрэлцээтэй тэжээллэг хоол хүнс, доромжлол хүчирхийллээс хамгаалан хайрлаж асардаг гэр бүлээс эхлээд бүхэлдээ хүүхэд насанд хүэргчдийн үүргийг орлохгүйгээр тоглох, суралцах, нийгэмших, иргэнийхээ үүрэг хариуцлагад суралцах, хүлээн зөвшөөрөгдөх, эрүүл бөгөөд аюулгүй орчноор хангагдах эрхүүдийг багтаасан ойлголт юм.

Хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх байгууллага, аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд, олон нийтийн хүүхдэд ээлтэй хандлага, хувийн үзэл бодол, хэм хэмээ, түүнчлэн оролцоо, ардчилал, шударга ёс, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг зарчмуудад хэрхэн ханддагаас их хамаардаг.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр олон чухал арга хэмжээ авч байгаа хэдий ч, нийгэм, эдийн засгийн чадавхи, ажилгүйдэл, ядууралтай холбоотойгоор хүүхдийн эрх зөрчсөн олон асуудлууд анхаарал татсаар байна.

Судалгаанаас харахад ураг, нярайн болон нялхсын эндэгдэл олон аймагт улсын дунджаас дээгүүр байгаа, хүүхэд, өсвөр насныханд үзүүлж буй эрүүл мэндийн анхан шатны тусламж шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа, хүүхдийн эмч бэлтгэх, мэргэшүүлэх бодлого алдагдсан, ерөнхий боловсролын сургууль болон дотуур байрны хүртээмж хангалтгүй, сургууль завсардалт өндөр, бага насны болон насанд хүүхдүүд хүнд, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй, гэмт хэрэг болон хараа хяналтгүй хүүхдийн тоо харьцангуй их зэрэг хүүхдийн амьдрах, сурч боловсрох, хөгжих эрхүүдтэй холбоотой тулгамдсан асуудлууд анхаарал татаж байна.



### **Эрх зүйн орчин**

2000 оны улсын хүн амын нэгдсэн тооллогоор манай улсын хүн ам 2375,5 мянгад хүрч, нийт хүн амын доторхи хүүхдийн эзлэх хувийн жин өндөр хэвээр, 46,6 хувийг 18 хүртэлх насныхан, 12,1 хувийг 19-24 насныхан эзэлж байна.

Өнөөдөр Монгол улсад 310 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагийн 60 орчим хуульд хүүхэд, хүүхдийн эрхийн холбогдолтой 350 орчим заалт тусгагдсан байна.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцид нэгдэн орж, Конвенцийн үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгох ажлыг шат дараатай хийж, 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг батлан гаргасан. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар хүүхдийн амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхүүдийг тодорхойлж, эдгээр эрхийг хангахад оролцох төр, нийгмийн оролцооны эрх зүйн үндсийг тогтоож өгсөн. Мөн Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн үзэл санааг хэрэгжүүлэх үүднээс 2002 онд Монгол Улсын Засгийн газраас “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн.

Түүнчлэн Монгол Улс хүүхдийн хөдөлмөрийн талаархи Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Аж үйлдвэрт ажилд авах насны доод хэмжээний тухай 59 дүгээр конвенци, Газрын доорх ажилд авах насны доод хэмжээний тухай 123 дугаар конвенци, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хүнд хэлбэрийг хориглох болон устгах тухай 182 дугаар конвенци зэрэг холбогдох конвенциудад нэгдэн орж тодорхой ажлуудыг зохион байгуулж байна.

### **Хүүхдийн хөдөлмөр**

Олон улсын түвшинд хүүхдийн хөдөлмөр гэдэгт хүүхдийн эрүүл мэнд, бие бялдар, ёс суртахууны хөгжилд хор хөнөөлтэй, аюултай нөхцөлд хийж буй хөдөлмөрийн харилцаа үүсгэсэн болон үүсгээгүй үйл ажиллагааг хэлдэг. Өөрөөр хэлбэл энэ нь хүүхэд ямарваа ажлыг өөрийн болон бусдын амьдралыг загуулахын төлөө ямар нэгэн хэмжээгээр тогтмол байдлаар хийхийг хэлдэг.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлээр насанд хүрээгүй хүний хөдөлмөрийг зохицуулсан. Хуульд 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй бөгөөд 15 насанд хүрсэн хүн эцэг, эх буюу харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно гэж заасан. Түүнчлэн мэргэжлийн баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 14 насанд хүрсэн хүнтэй эцэг эх, асран хамгаалагч болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хөдөлмөрийн гэрээ байгуулж болно.

Хуулиар насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэхийг хатуу хориглосон. Түүнчлэн насанд хүрээгүй хүнийг ажилд авахад ажил олгогчид хуулиар насанд хүрээгүй хүнийг эмнэлгийн үзлэгт орсны дараа ажилд авах бөгөөд түүнийг 18 насанд хүртэл нь хагас жил тутам эмнэлгийн үзлэгт хамруулах насанд хүрээгүй ажилтныг шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр ажиллуулахгүй байх зэрэг тодорхой үүрэг ногдуулсан. Гэвч хуулийн эдгээр заалтууд амьдрал дээр хэрэгжих нь хангалтгүй байна.

Улсын хэмжээгээр албан болон албан бус салбарт хичнээн хүүхэд хөдөлмөр эрхэлдэг болох талаар нэгдсэн тоо баримт байдаггүй ч ХЭҮК-оос 2003 оны эхний улиралд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн асуудлаар хийсэн судалгаа, ОУХБ болон бусад ТББ-уудаас хийсэн судалгаанаас үзэхэд бага насны болон насанд хүрээгүй хүмүүс эрүүл энх өсч хөгжихөд сөрөг нөлөөтэй хүнд, тэвчишгүй хэлбэрийн ажил хөдөлмөр эрхлэх нь бага биш байна.

ХЭҮК-оос бусад байгууллагатай хамтарч нийслэл болон хөдөө, орон нутагт хийсэн судалгаанаас үзвэл хүүхдүүд эрүүл мэнддээ сөрөг нөлөө үзүүлж болох дорхи төрлийн ажил хөдөлмөрийг эрхэлж байна.

1. Алтны ордуудад томчуудын нэгэн адил шороо зөөх, ухах, ачиж буулгах, чулуу бутлах, мөнгөн ус зэрэг хорт бодистой харьцаж ажиллах.
2. Нийслэлийн Налайх дүүргийн нүүрсний уурхайд 200-300 хүүхэд тогтмол ажиллаж, нүүрс чирж гаргах, шигших, түүх зэрэг хүнд хортой хөдөлмөр эрхлэх
3. Хүнс, бараа, нүүрсний зэрэг зах дээр ажиллах. Нийслэлийн зургаан дүүргийн том, бага 31 зах дээр 1000 гаруй хүүхэд хөдөлмөр эрхэлдэг байна
4. Монголын уламжлалт мал аж ахуй, ёс заншилтай холбоотойгоор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй буюу хүнд хөдөлмөрт тооцогдох хүний мал маллах, олон малтай айл өрхөд хөлстэй, хөлсгүй зарагдах явдал түгээмэл болсон байна.
5. Түүнчлэн уралдааны хурдан морь унаж буй хүүхдийн эрхийн асуудал хурцаар тавигдаж олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандах явдал нэлээд гарах болов.

Үүнээс гадна насанд хүрээгүй хүмүүс /16-18 насны/ үйлдвэр, аж ахуйн газруудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нь цөөнгүй байна. Насанд хүрээгүй хүмүүсийн хөдөлмөрийн харьцааг хөдөлмөрийн хуульд тусгайлан заасан боловч энэхүү заалт амьдралд тэр бүр хэрэгжихгүй байна. ХЭҮК-оос нийслэл болон Дархан-Уул аймгийн гадаадын хөрөнгө оруулалттай 24 үйлдвэрт хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тэднийг тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулдаггүй, илүү цагаар болон хөдөлмөрийн хуульд зааснаас илүү хугацаагаар ажиллуулдаг зэрэг зөрчил илэрч байсан.

Судалгаагаар ядуу амьдралтай өрхийн хүүхдийн хөдөлмөрийг ямар ч гэрээ хэлцэлгүйгээр, цалин хөлсгүйгээр ашиглаж, завших, тэд боловсрол эзэмших, сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй хохирох хандлага газар авч байна гэсэн дүгнэлт хийсэн. Иймд, Хүүхдийн эрхийн хэрэгжилт, ялангуяа тэдгээрийн хөдөлмөртэй холбоотой асуудалд үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд, түүний гишүүдийн үүрэг оролцоо чухал юм.

Улаанбаатар хот

**ӨВЛИЙН МОРИН УРАЛДААНЫ УНААЧ  
ХҮҮХДИЙН БОДИТ НӨХЦӨЛ**



**БАГАНУУР ДҮҮРЭГ**

2006 оны хоёрдугаар сарын 05

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Хүүхдийн төлөө Үндэсний газар

## Танилцуулга

Жилд дунджаар хурдан морины 500 гаруй уралдаан төв орон нутагт зохиогдож, 150-180 мянга орчим морийг 50.000 гаруй уяачид уян, 30.000 орчим хүүхэд унаж уралддаг байна.

Үндэсний их баяр наадмын үеэр өнгөрсөн жилүүдэд маш олон хүүхэд унаж, бэртэл авч байсан бөгөөд 4 хүүхэд өмнөлгийн тусламж авч чадалгүй нас барж байсан.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд хууль дүрэм, заагдсан шаардлагыг үл хангасан зугаа цэнгэлийн хэлбэртэй, мөрийтэй бооцоот уралдаан олноор зохион байгуулан бага насны хүүхдийг оролцуулж байгаа нь хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Үндэсний Их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан, Монгол Улсын шадар сайдын "Хурдан морины хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай" тушаал батлагдан гарсан юм.

Хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангахад:

1. Хүүхдийн төрсний гэрчилгээ, хурдан морь унахыг зөвшөөрсөн эцэг эх, асран хамгаалагчийн тодорхойлолт, ослын даатгалд хамрагдсан эсэхийг үндэслэн, 7-гоос дээш насны хүүхдийг бүртгэх.
2. Өвлийн удиралд болон -18 хэмээс хүйтэн тохиолдолд хурдан морины уралдааныг зохион байгуулахгүй байх.
3. Хүүхэд хүсэхгүй бол уралдаанд оролцохоос татгалзах эрхтэй байх.
4. Унаач хүүхэд хамгаалалтын бүрэн хэрэгслэлтэй уралдах зэрэг заалтуудыг тусгасан.

Эдгээр заалтуудын хэрэгжилтийг хянах зорилгоор Засгийн газрын тогтоолоор морин уралдааны хуваарийг батлан гаргасан бөгөөд уралдааны үеэр хяналт тавин ажиллаж эхлээд байна.

2006 он гарсаар Хаврын тэргүүн сарын шинийн 3 буюу 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Монголын Морин уралдааны холбооноос -30 хэмийн хүйтэнд хурдан морины уралдаан зохион байгуулсан нь оролцогч хүүхдүүдийн гар, хөл хайрагдахад хүргэжээ.

Иймд тус газар Багануур дүүрэгт зохион байгуулагдсан Зүүн бүсийн уралдааны үеэр хүүхдийн нөхцөл байдлыг судлан ажиллалаа.

Багануур дүүрэгт зохион байгуулагдсан уралдааны тухай:

Уралдааны комиссыг албан ёсоор дүүргийн Засаг даргын захирамжаар батлан гаргасан бөгөөд Хүүхдийн аюулгүй байдлыг

хангах бэлтгэл ажлыг дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Ш.Отгонбаяр хариуцан ажилласан.

Уралдаанд оролцох хүүхдийн бүртгэлийг Хүүхдийн төлөө төвийн арга зүйч нар хариуцан ажилласан.

Уралдаанд Азарга /145/, их насан/162/ морь уралдан, нийт 307 морь уралдсан.

Нийт 170 гаруй хүүхэд бүртгүүлснээс ослын даатгалд 160 хүүхэд хамрагдсан байсан нь баяр наадмын уралдаанд жилээр даатгалд хамтрагдсан хүүхдүүд байна.

Нийт 8 хүүхэд мориноос унасан, 2 хүүхэд хөнгөн бэртсэн байна.

Мөн наадмын төгсгөлд урьдчилж төлөвлөөгүйгээр уячид хоорондоо тохиролцон Соёлон насны морьдын бооцоот уралдааныг зохион байгуулахад 30 орчим морьд уралдан, тэр тооны хүүхдүүд оролцсон. Азаар хүүхэд унах, бэртэх явдал гараагүй цаг агаарын байдал дулаан байсан.

Дүүргийн цагдаа нар эмх замбараагүй байдлыг үүсгэхгүйн үүднээс хамгаалалт хийсэн.



Бооцоот уралдаанд оролцоход 50.000 төгрөгийг тушаах шаардлагатай бөгөөд аюулгүй байдлыг хангах баталгаа огт хийгдээгүй байна





Зохион байгуулах комиссын мэдээлснээр хотоос болон Налайх дүүргээс цагдаа нарыг дайчлан нийт 180 гаруй цагдаагийн хамгаалалт гаргаж, машин нэвтрүүлэхгүй зорилгоор 3 бартаа тавьсан боловч машины тоо, хүч дийлдээгүй гэж хэлсэн.

### МЭДЭГДЭЛ

Монголын соёл иргэншил, үндэсний уламжлалт спортын нэг болсон шандаст хурдан хүлэг морьдын уралдаан нь хүн бүрийн хийморь сэргээсэн унаач хүүхдийн авхаалж самбааг сорьсон торгон агшин байдаг билээ.

Энэ нь үндэсний баяр наадмын нэг боловч унаж уралдсан хүүхэд багачуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл дагуулдаг учир хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 119-р тогтоолоор “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны шинэчилсэн дүрэм”, тухайн жилд зохион байгуулагдах уралдааны нэгдсэн хуваарийг батлан гаргасан.

Дүрэмд өвлийн улиралд хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглож, хурдан морины уралдаанд хүүхдийг оролцуулахдаа эцэг, эхийн зөвшөөрөлтэй / баталгаажсан / байх, ослын даатгалд хамруулах, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх тухай заасан байдаг.

Сүүлийн үед хурдан морины уралдаан нь спорт бус зугаа цэнгэл, ашиг хонжооны хэлбэртэй болж, хүүхдийн амьд явах, эсэн мэнд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байна. Саяхан Макс Импекс ХХК-ны захирал Д.Ганбаатарын тэргүүлсэн Монголын Морин уралдааны холбооноос дур мэдэн морин уралдаан зохион байгуулсанаас унаач хүүхдүүд 30 хэмийн хүйтэнд даарч бээрэх, хацар, гар хайрагдах, ханиад хүрэх, хатгаа авах, хоолой өвдөх зэргээр эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол гарлаа.

Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд харгалзан үзэж, дүрэм журмаа дагаж мөрдөж байхыг морин уралдаан зохион байгуулагчдад анхааруулан, цаашид хүүхдийн эрхийг зөрчсөн байгууллага, хувь хүн хэнийг ч болов шүүхэд хандан, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авна гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна.

Олон нийт эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд багачууд та бүхнийг орон нутгийнхаа хэмжээнд зохион байгуулж буй морин уралдаануудад хяналт тавин хүүхдийн эрхийг хамгаалахад бидэнтэй хамтран ажиллахыг уриалъя

## Бодит түүх-1



Б.Цолмон /Нийслэлийн 73-р  
Сургуулийн 6-р ангийн сурагч,  
12 настай/

Морин уралдааны барианы талбайн урд байрласан гал командын машинаас “-24 номертой уралдсан хүүхэд мориноосоо унасан тул ирж авна уу” гэж зарлана.

Зарын дагуу очиж уулзвал “- Их насны морины уралдаанд 2 хүүхэд мориноосоо уналаа 1-ийг нь эмнэлэг рүү аваад явсан. Энэ хүүхэд гайгүй байгаа учраас үлдээгээд байна” гэлээ.

Хүүхэдтэй уулзах үед тэрээр уйлчихсан, доголон нуламстай хэвээр байсан бөгөөд нүүр, хувцас нь шороо тоосонд дарагдан, мориныхоо хөлсөнд норж, хацар гар нь бага зэрэг шалбарсан, байлаа.

Унаач хүүхэд Б.Цолмон: Уралдааны үеэр машинууд хажуугаар их давхисан. Бужигнасан тоосонд нь замаа сайн харахгүй байсан учраас жалган дээгүүр харайхад мориноосоо уначихсан. Гэмтэл аваагүй, унасан газраараа жаахан хөндүүрлэж байна. Өвлийн уралдаанд анх удаа оролцсон. Хэцүү байдаг юм байна. Энэ удаад танин айлынхаа морийг унаж уралдсан.



2006.02.05-ны Багануур дүүрэгт зохион  
байгуулагдсан уралдааны үеэр морьдыг үзэгчдийн  
машин дагаж байгаа нь

ЦНМН  
СЭДАЛГААНЫ САН



Бодит түүх-2



Н.Амартүвшин /Багануур дүүргийн задгайд амьдардаг, 10 настай/

Морины хүүхэд унаж, эмнэлэгт хүргэгдсэн тухай товруулахаар дүүргийн эмнэлгийг зорилоо.

Эмнэлэгт очиход үзлэг хийгдээд дуусах дөхөж байв. Эмчийн хэлснээр хүүхэд мөрөөрөө унаснаас болж, мөрний үеэрээ гэмтэл авсан байж болзошгүй. Уг нь рентгенд зургийг нь авахуулах гэсэн боловч амралтын өдөр таарсан тул ажиллахгүй байна гэлээ.

Уяач хүүхдийг авахаар ирчихсэн, хувцаслаж байх зуур хэдэн үг солилоо.

Дүүргийн жижүүрийн эмч Д.Оюунгэрэл: Хүү зүүн мөрний үеэрээ гэмтсэн байж болзошгүй. Гадуур үзлэг хийгээд, гайгүй болохоор нь явуулах гэж байна. Азарганы уралдаанд бас 2 хүүхэд мориноосоо унасан. Гэхдээ зүгээр, харин гараанаас гарах үедээ 1 хүүхэд моринд өшиглуулэн, хөлийн булчин нь язарсан ирсэн. Хөлөнд нь 4 оёо тавьж өгсөн. Ер нь баяр наадмын үеэр ч, их бага уралдаануудын үеэр олон хүүхэд гэмтэж, бэртэж ирдэг. Дүүргийн эмнэлгээс нутаг дэвсгэрт зохион байгуулагддаг уралдаанд гарч ажилладаг. Гэхдээ анхан шатны тусламжийн зүйлс хамт байлгадаггүй, эмнэлэг ойрхон учир, зөвхөн түргэн тусламжийн машиныг л ажиллуулж, осол гарсан тохиололд эмнэлэгт авчруулдаг.

Унаач хүүхэд Н.Амартүвшин: Уралдаанд хамаатныхаа морийг унаж уралдаж байна. 4 жил морь унасан боловч анх удаагаа өвлийн уралдаанд оролцож байна. Жаахан тиймхэн л байдаг юм байна. Машинууд их замбараагүй байсан. Жалгаар гарах гэж байгаад мориноосоо уначихсан.

Уяач: Уралдаанд оролцохоор бүртгүүлэхдээ ямар ч бичиг баримт гээгүй, шууд очоод л номероо авчихсан. Зуны уралдаанд даатгал хийлгэсэн.

Хүүхдийн төлөө Үндэсний газар

40

**ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН УЛАМЖЛАЛТ СПОРТ УУ, ЗУГАА ЦЭНГЭЛ ҮҮ**  
**ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН УЛАМЖЛАЛТ СПОРТ УУ, ЗУГАА ЦЭНГЭЛ ҮҮ**  
**ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН УЛАМЖЛАЛТ СПОРТ УУ, ЗУГАА ЦЭНГЭЛ ҮҮ**  
**ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН УЛАМЖЛАЛТ СПОРТ УУ, ЗУГАА ЦЭНГЭЛ ҮҮ**  
**ХУРДАН МОРИНЫ УРАЛДААН УЛАМЖЛАЛТ СПОРТ УУ, ЗУГАА ЦЭНГЭЛ ҮҮ**



ᠮᠣᠩᠭᠣᠯ  
ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠲᠤ  
ᠰᠢᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ  
ᠰᠠᠷᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠰᠤ

Хэвлэлийн хуудас

Улаанбаатар хот

2006.02.06

Харилцах хүн: Ж.Оюунцэцэг /Хэвлэлийн төлөөлөгч/  
Утас: 262914, 99249848  
Факс: (+976-11) 322048  
E-mail: ncc@magicnet.mn

### Зугаа цэнгэлд хүүхдийг оролцуулахыг хуулиар хориглодог

Жилд дунджаар хурдан морины 500 гаруй уралдаан төв орон нутагт зохиогдож, 150-180 мянга орчим морийг 50.000 гаруй уяачид уян, 30.000 орчим хүүхэд унаж уралддаг байна.

Үндэсний их баяр наадмын үеэр өнгөрсөн жилүүдэд маш олон хүүхэд унаж, бэртэл авч байсан бөгөөд 4 хүүхэд өмнөлгийн тусламж авч чадалгүй нас барж байсан.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд хууль дүрэм, заагдсан шаардлагыг үл хангасан зугаа цэнгэлийн хэлбэртэй, мөрийтэй бооцоот уралдаан олноор зохион байгуулан бага насны хүүхдийг оролцуулж байгаа нь хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор Үндэсний Их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан, Монгол Улсын шадар сайдын "Хурдан морины хүүхдийн аюулгүй байдлыг хангах тухай" тушаал батлагдан гарсан юм. Эдгээр дүрэм, зааварт хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангахад:

1. Хүүхдийн төрсний гэрчилгээ, хурдан морь унахыг зөвшөөрсөн эцэг эх, асран хамгаалагчийн тодорхойлолт, ослын даатгалд хамрагдсан эсэхийг үндэслэн, 7-гоос дээш насны хүүхдийг бүртгэх
2. Өвлийн удиралд болон -18 хэмээс хүйтэн тохиолдолд хурдан морины уралдааныг зохион байгуулахгүй байх
3. Хүүхэд хүсэхгүй бол уралдаанд оролцохоос татгалзах эрхтэй байх
4. Унаач хүүхэд хамгаалалтын бүрэн хэрэгслэлтэй уралдах зэрэг заалтуудыг тусгасан.

Эдгээр заалтуудын хэрэгжилтийг хянах зорилгоор Засгийн газрын тогтоолоор морин уралдааны хуваарийг батлан гаргасан бөгөөд уралдааны үеэр хяналт тавин ажиллаж эхлээд байна.

2006 он гарсаар Хаврын тэргүүн сарын шинийн 3 буюу 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Монголын Морин уралдааны холбооноос -30 хэмийн хүйтэнд хурдан морины уралдаан зохион байгуулсан нь оролцогч хүүхдүүдийн гар хөл хайрагдахад хүргэсэн байна.

Иймд тус газар Хүүхдийн эрхийн тухай хуулийн 23-р зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ биелүүлэн, хүүхдийг эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох арга хэмжээг аван ажиллах илэрхийлэн мэдэгдэл гаргасан

бөгөөд Багануур дүүрэгт зохион байгуулагдсан Зүүн бүсийн уралдааны үеэр хүүхдийн нөхцөл байдлыг судлан үзэхэд:

- Уралдааны комиссыг албан ёсоор дүүргийн Засаг даргын захирамжаар батлан гаргасан бөгөөд Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бэлтгэл ажлыг дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Ш.Отгонбаяр хариуцан ажилласан.
- Уралдаанд Азарга /145/, их насан/162/ морь уралдан, нийт 307 морь уралдсан.
- Нийт 170 гаруй хүүхэд бүртгүүлснээс ослын даатгалд 160 хүүхэд хамрагдсан байсан нь баяр наадмын уралдаанд жилээр даатгалд хамрагдсан хүүхдүүд байсан.
- Нийт 8 хүүхэд мориноос унасан, 2 хүүхэд хөнгөн бэртсэн байна.
- 100 гаруй машин уралдааныг даган давхисан нь шороо тоос босгон, морьдийг хашиж, уралдааныг эмх замбараагүй болгосон
- Мөн наадмын төгсгөлд урьдчилж төлөвлөөгүйгээр уячид хоорондоо тохиролцон Соёлон насны морьдын бооцоот уралдааныг зохион байгуулахад 30 орчим морьд уралдан, тэр тооны хүүхдүүд оролцсон. Азаар хүүхэд унах, бэртэх явдал гараагүй цаг агаарын байдал дулаан байсан.

Түүнчлэн мөн өдөр Өвөрхангай аймагт хурдан морины уралдаан зохион байгуулагдсан бөгөөд орон нутгийн холбогдох ажилтнуудаас мэдээллийг авахад:

- Аварга, Соёлон, Их насны уралдаанд нийт 158 морь уралдахад, давхардсан тоогоор 130-аад оролцсон
- 3 хүүхэд унасан боловч азаар бэртэл аваагүй
- Даатгалд унаач хүүхдүүдийг хамруулаагүй бөгөөд зөвхөн нэг хүүхэд аюулгүйн хэрэгсэлтэй уралдсан
- Уралдааны маршрут гол гатлахаар байсан нь халтиргаа үүсгэсэн, машинууд уралдааныг дагаж давхисан зэрэг нь хүндрэл учруулсан байна.

Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд харгалзан үзэж, дүрэм журмаа дагаж мөрдөж байхыг морин уралдаан зохион байгуулагчдад анхааруулан, олон нийт эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд багачууд та бүхнийг зохион байгуулж буй морин уралдаануудад хяналт тавин хүүхдийн эрхийг хамгаалахад бидэнтэй хамтран ажиллахыг уриалъя.

**Хүүхдийн төлөө Үндэсний газар**

**UIN.MN**  
СУДАЛГААНЫ САН

бөгөөд Багануур дүүрэгт зохион байгуулагдсан Зүүн бүсийн уралдааны үеэр хүүхдийн нөхцөл байдлыг судлан үзэхэд:

- Уралдааны комиссыг албан ёсоор дүүргийн Засаг даргын захирамжаар батлан гаргасан бөгөөд Хүүхдийн аюулгүй байдлыг хангах бэлтгэл ажлыг дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Ш.Отгонбаяр хариуцан ажилласан.
- Уралдаанд Азарга /145/, их насан/162/ морь уралдан, нийт 307 морь уралдсан.
- Нийт 170 гаруй хүүхэд бүртгүүлснээс ослын даатгалд 160 хүүхэд хамрагдсан байсан нь баяр наадмын уралдаанд жилээр даатгалд хамрагдсан хүүхдүүд байсан.
- Нийт 8 хүүхэд мориноос унасан, 2 хүүхэд хөнгөн бэртсэн байна.
- 100 гаруй машин уралдааныг даган давхисан нь шороо тоос босгон, морьдийг хашиж, уралдааныг эмх замбараагүй болгосон
- Мөн наадмын төгсгөлд урьдчилж төлөвлөөгүйгээр уячид хоорондоо тохиролцон Соёлон насны морьдын бооцоот уралдааныг зохион байгуулахад 30 орчим морьд уралдан, тэр тооны хүүхдүүд оролцсон. Азаар хүүхэд унах, бэртэх явдал гараагүй цаг агаарын байдал дулаан байсан.

Түүнчлэн мөн өдөр Өвөрхангай аймагт хурдан морины уралдаан зохион байгуулагдсан бөгөөд орон нутгийн холбогдох ажилтнуудаас мэдээллийг авахад:

- Аварга, Соёлон, Их насны уралдаанд нийт 158 морь уралдахад, давхардсан тоогоор 130-аад оролцсон
- 3 хүүхэд унасан боловч азаар бэртэл аваагүй
- Даатгалд унаач хүүхдүүдийг хамруулаагүй бөгөөд зөвхөн нэг хүүхэд аюулгүйн хэрэгсэлтэй уралдсан
- Уралдааны маршрут гол гатлахаар байсан нь халтиргаа үүсгэсэн, машинууд уралдааныг дагаж давхисан зэрэг нь хүндрэл учруулсан байна.

Хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд харгалзан үзэж, дүрэм журмаа дагаж мөрдөж байхыг морин уралдаан зохион байгуулагчдад анхааруулан, олон нийт эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд багачууд та бүхнийг зохион байгуулж буй морин уралдаануудад хяналт тавин хүүхдийн эрхийг хамгаалахад бидэнтэй хамтран ажиллахыг уриалъя.

**Хүүхдийн төлөө Үндэсний газар**

**UIN.MN**  
СУДАЛГААНЫ САН



44

**ХУРДАН МОРИНЫ ХҮҮХДҮҮДИЙН ДУНД ГЭМТЭЛ, ОСЛЫН ТАЛААРХИ  
ТОХИОЛДЛУУД БОЛОН БАРИМТ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ  
АЖЛЫН УДИРДАМЖ**

## **1. Үндэслэл**

...саяхныг хүртэл Наадам нь хурдан морь уралдуулах үндсэн шалтгаан байсан бөгөөд морин уралдааныг зөвхөн зуны улиралд зохион байгуулдаг байсан. Сүүлийн үед нэгэн шинэ чиг хандлага маш хурдацтай гарч ирсэн нь морин холбоод байгуулагдаж, хөгжиж эхэлсэнтэй холбоотой. Үүнтэй холбогдуулан:

- Уламжлалт ёс заншлын дагуу морьдыг малчид өөрсдөө сойж бэлтгэдэг байсан бөгөөд энэ нь малчдын болон олон нийтийн баяр ёслол байсан юм. Уяач болон хүүхэд нь морьдыг өөрсдөө бэлтгэдэг байсан бол одоо энэ нь өөрчлөгдөж байна. Улс төрчид болон бизнесменүүд хурдан морьдыг эзэмших болж энэ нь тэдгээрийн нэр хүнд, компаний сурталчилгааны нэг арга хэрэгсэл болсон байна.
- Бизнесменүүд болон олны дунд нэр алдартай уяачид болон хэд хэдэн хүүхдүүдийг хөлслөн авдаг. Тодорхой хэдэн бизнесменүүд болон уяачид нийлж нэг "Гал" үүсгэдэг байна. Тэдгээр нь маш олон тоогоор морьдыг сойж бэлтгэдэг бөгөөд нэг "Гал"-д мөн олон тооны хүүхдүүд харьяалагддаг байна.
- Өвлийн цагт (Цагаан сарын дараагаар) хурдан морины уралдааныг илүү ихээр зохион байгуулах болсноор хурдан морины хүүхдүүд эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хүнд хэлбэрийн осол, гэмтэлд өртөх эрсдэл их болдог байна. Иймд олон нийтийн зүгээс өвлийн уралдааныг ихээхэн шүүмжлэх болсон байна.
- Үүнтэй холбоотой гарсан осол аваар болон ноцтой гэмтлийн талаархи тохиолдлуудыг хүмүүс ихээхэн мэдэх болсон ч энэ нөхцөл байдлыг ил тод болгох талаар мэдээлэл цуглуулах тогтсон тогтолцоогүй байна.
- Хэдийгээр Монгол улсын Шадар Сайдын 2005 оны эхэн үеийн журмаар хамгаалалтын хэрэгсэлийг хэрэглэх тухай тусгасан боловч, хамгаалалтын малгай болон хувцас хэрэглэх нь маш хангалтгүй байгаа. Мөн энэ талын тодорхой стандарт одоогоор байхгүй, энэ талын ойлголт болон хүсэл эрмэлзэл тааруухан байгаа болно.
- Бага хэмжээний, орон нутгийн хурдан морины уралдааныг малчид өөрсдөө байнга зохион байгуулдаг ба энэ нь тухайн малчин төрийн шагнал хүртсэн тохиолдолд шагналын угаалга, цайллагын нэг хэсэг болж байдагтай холбоотой.

2006 онд Төв аймагт болсон Цагаан сарын хурдан морины уралдааны дараагаар өвлийн цагт хурдан морь уралдуулах асуудлыг хөндөж сэтгүүлчид болон үндэсний байгууллагуудын (Хүүхдийн төлөө үндэсний газар, ХЭҮК г.м.) зүгээс ихээхэн анхаарал татсан юм. Эдгээр хоёр байгууллагууд нь "Хурдан морины хүүхдийн үндэсний Чуулган"-ыг 2006 оны 5 сарын эхээр зохион байгууллахаар тохиролцон шийдвэрлэсэн бөгөөд үүний бэлтгэл ажлын хүрээнд осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, тэдгээрийг боловсруулах ажилд оролцох үүнийг дэмжих, олон нийтийн үзэл бодолд нөлөөлөх, хурдан морины хүүхдийг хамгаалах эрх зүйн тогтолцоог сайжруулах үүднээс санал зөвлөмж дэвшүүлэх чиглэлээр ажиллана. Чуулганыг зохион байгуулах ажлыг мөн Биеийн тамир, урлаг



спортын улсын хороо, Өвөрхангай аймгийн “Арвагар хээр” морин спортын нийгэмлэг дэмжиж байгаа юм.

Үндэсний Чуулганыг зохион байгуулах бэлтгэл ажил боловсруулалтын шатандаа байгаа бөгөөд энэ үйл ажиллагааны хүрээнд:

- Хурдан морины нийгэмлэгүүдийн төлөөлөгчдийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулах;
- Улаанбаатар хотын 9 дүүргээс болон бүх 21 аймгаас хурдан морины хүүхдүүдийг шалгаруулах;
- Үндэсний Чуулганы үеэр болох уяачид болон морин холбоодын уулзалтыг зохион байгуулах ажилд бэлтгэх;
- Чуулганы талаар олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн ажлыг явуулах

Түүнээс гадна, IPEC нь өөрчлөгдөж буй энэхүү нөхцөл байдалд санаа тавьж 2006 оны 3 дугаар сарын 11-нд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, ХЭҮК, Хүүхдийн төлөө үндэсний газар зэрэг холбогдох байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзалт зохион байгуулсан юм.

Уулзалтаар дараахи зүйлүүд дээр харилцан тохиролцов:

- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны удирдлаганд хурдан морины уралдааныг тойрсон өнөөгийн нөхцөл байдал, уяалдаа холбоог судлах цаашдын ажлыг хийх шаардлагатай ба хурдан морины хүүхдийг хамгаалах эрх зүйн тогтолцоог сайжруулахад санал оруулах;
- Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны удирдлаганд илүү дэлгэрэнгүй болон хэрэгцээнд нийцсэн аюулгүйн стандартуудыг тогтоох цаашдын ажлыг хийх шаардлагатай;
- ХЭҮК болон Хүүхдийн төлөө үндэсний газрын удирдлаганд энэ талаар олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх стратеги болон энэ талын мэдээлэл, сурталчилгааны материалыг боловсруулах;
- ХЭҮК болон Хүүхдийн төлөө үндэсний газрын удирдлаганд Хурдан морины хүүхдийн үндэсний Чуулганыг бэлтгэх;
- Сүүлийн 3 жилийн хугацаанд хурдан морины хүүхдийн гэмтэл, ослын талаарх мэдээллийг цуглуулах;
- ILO IPEC-ээс санхүүгийн дэмжлэг хүсэх

Ингэснээр, Монгол улсын бүх аймгуудаас хурдан морины хүүхдийн осол, гэмтэлтэй холбоотой үндсэн мэдээллийг цуглуулснаар хурдан морины хүүхдийн осол гэмтлийн тохиолдлуудын шалтгаан нөхцөлийн талаар мэдээллийн сантай болно. Энэхүү мэдээллийг бүх аймаг, дүүргүүдээс цуглуулах бөгөөд эдгээр нь болсон явдлуудаар баяжуулагдсан байна. Ийм мэдээлэл баримтыг дараах зүйлд ашиглана:

- 1) Уяачид, морин уралдааны нийгэмлэгүүд болон бизнесийн холбоодын төлөөлөгчдийн уулзалтын үеэр хүүхдийг хамгаалах асуудлаар нэгдсэн ойлголт, арга барилтай болгоход нөлөө бүхий хэрэгсэл болно;

- 2) Энэ талаар хийгдэх судалгааны ажлуудад чухал мэдээллийн эх сурвалж болохоос гадна хурдан морины хүүхдийн аюулгүйн байдлыг сайжруулахад санал оруулах юм.

## **2. Зорилго**

Цуглуулсан мэдээ баримтан дээр тулгуурласан мэдээлэл, хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн ажил нь хурдан морины хүүхдийг хамгаалах ажлыг сайжруулахад хувь нэмэр оруулаад зогсохгүй Монголын хэдэн зуун жилийн түүхтэй уламжлал ёс заншлын хамгийн хүнд хэцүү нөхцөл байдлыг арилгахад чиглэгдэнэ.

## **3. Үйл ажиллагааны болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тойм**

Дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлэх болон үр дүнд хүрнэ:

*Үр дүн:*

Улаанбаатар хот болон бүх 21 аймгуудаас хурдан морины уралдаан болон морь уях үеэр хурдан морины хүүхдийн осол, гэмлийн талаар суурь судалгааны мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх.

*Үйл ажиллагаа 1.1:*

Мэдээлэл цуглуулахтай холбоотой санал асуулгын хуудас болон удирдамжыг боловсруулах

*Үйл ажиллагаа 1.2:*

Санал асуулгын хуудас болон удирдамжийг нийслэл болон бүх аймгуудад явуулах

*Үйл ажиллагаа 1.3:*

ХЭҮК-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчид бүх сумдуудаас мэдээлэл цуглуулах ба холбогдох хүмүүс, байгууллагуудаас ярилцлага авах

*Үйл ажиллагаа 1.4:*

Мэдээ баримтан дээр дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж оруулах болон тэдгээрийг уяачдын уулзалтын үеэр болон бусад холбогдогдох байгууллагуудад (Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, Биеийн тамир, урлаг спортын улсын хороо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчдийн эвлэлүүдийн холбоо болон ILO-IPEC)-д танилцуулах.

## **4. Хэрэгжүүлэгч байгууллага**

Монгол улсын Хүний эрхийн үндэсний Комисс (ХЭҮК) нь төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. ХЭҮК нь энэхүү удирдамжинд тусгагдсан үйл ажиллагаануудыг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран хэрэгжүүлнэ (орон нутгийн төвшинд 2 байгууллагын төлөөлөгчид хамтран ажиллана).